

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2026/005/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn

Аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл	10
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорил, судалгааны үр дүн	12
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6.1 Завсрын аудитын талаар	12
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
5.2 Албан шаардлага	13
5.3 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ДЦС	Дулааны цахилгаан станц
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ГОРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Харлан сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.03.16 № 374

танай _____ -ны № _____ -т

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ
СИСТЕМ” ТӨХК ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ө.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

“Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВт-ын шинэ станцаар өргөтгөх” төсөл хэрэгжиж 2024 оны 10 дугаар сараас ашиглалтад орсон ч гүйцэтгэгч компани барилга байгууламжийг албан ёсоор хүлээлгэн өгөөгүй байна.

Бусад асуудлын хэсэг

“Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВт-ын шинэ станцаар өргөтгөх” төслийн Монгол Улсын хөгжлийн банканд төлөх урт

2126050102

хугацаат зээлд 17,448.5 сая төгрөгийн валютын ханшийн зөрүүгийн бодит бус алдагдал үүссэн байна.

Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. БОЛОРТУУЛ

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант үе	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтах хөрөнгө	505,610,115.82	801,842,032.48
1.1.2	Дансны авлага	1,583,178,451.33	2,257,716,913.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,297,983,130.95	1,514,242,577.06
1.1.4	Бусад авлага	124,417,659.14	144,724,092.63
1.1.6	Бараа материал	5,544,933,928.53	3,741,537,124.02
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	22,289,502.50	28,341,146.39
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	126,867,500.00	57,299,500.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,205,280,288.27	8,545,703,386.04
1.2.1	Үндсэн хөрөнгө	348,518,986,848.55	365,367,330,344.85
1.2.2	Биет бус хөрөнгө	19,018,997,208.95	19,205,031,568.97
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	367,537,984,057.50	384,572,361,913.82
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	376,743,264,345.77	393,118,065,299.86
2.1.1.1	Дансны өглөг	21,050,004,977.67	27,230,054,272.34
2.1.1.3	Татварын өр	4,367,208,055.70	1,780,866,273.84
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,286,409.04	-
2.1.1.6	Хүүний өглөг	2,632,126,047.20	4,939,284,380.76
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	113,412,128.55	2,016,574,569.14
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	28,164,037,618.16	35,966,779,496.08
2.1.2.1	Урт хугацаат зээл	199,417,924,298.59	209,457,050,091.27
2.1.2.5	Хойшлогдсон орлого	68,698,699,283.66	68,521,295,699.07
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	268,116,623,582.25	277,978,345,790.34
2.2	Өр төлбөрийн нийт дүн	296,280,661,200.41	313,945,125,286.42
2.3.1	-төрийн	51,590,219,512.43	51,590,219,512.43
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,106,873,783.86	37,331,043,935.36
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,427,130,553.03	18,668,914,960.03
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-661,620,703.96	-661,620,703.96
2.3.10	Тайлант үеийн Хуримтлагдсан ашиг		-27,755,617,690.42
2.3.11	Эздийн өмчийн дүн	80,462,603,145.36	79,172,940,013.44
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	376,743,264,345.77	393,118,065,299.86

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 -р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	75,118,772,206.86	108,365,224,565.84
2	Борлуулалтын өртөг	58,695,307,902.21	79,501,437,430.06
3	Нийт ашиг/алдагдал/	16,423,464,304.65	28,863,787,135.78
4	Түрээсийн орлого	35,063,605.10	42,438,040.07
5	Хүүний орлого	45,404,846.77	44,241,530.49
8	Бусад орлого	8,076,051,337.37	1,011,913,661.93
9	Борлуулалт, маркетингийн зардал	14,673,484,590.13	17,562,468,250.15
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,075,364,814.15	4,039,104,009.36
11	Санхүүгийн зардал	6,136,127,774.22	15,747,560,254.40
12	Бусад зардал	4,129,667,060.63	4,008,042,351.90
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,678,668,830.90	-16,360,823,192.88
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,755,991,314.34	-27,755,617,690.42
19	Орлогын татварын зардал	136,397,253.44	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,892,388,567.78	-27,755,617,690.42
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-1,892,388,567.78	-27,755,617,690.42
24	Орлогын нийт дүн	-1,892,388,567.78	-27,755,617,690.42

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	88,906,916,695.83	118,757,271,945.03
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	80,282,387,914.42	117,952,071,097.72
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	1,430,512.00	11,670,033.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	5,791,100,000.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,831,998,269.41	793,530,814.31
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	75,171,491,160.50	107,669,968,937.74
1.2.1	Ажилчдад төлсөн	24,161,888,820.94	29,498,214,580.86
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,265,481,290.00	8,772,982,255.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,905,720,760.77	3,563,885,496.96
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,591,017,031.78	33,400,331,867.25
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	8,204,473,549.14	12,747,798,504.63
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,080,193,892.36	12,810,767,571.62
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	128,525,966.66	186,931,918.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,834,189,848.85	6,689,056,743.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,735,425,535.33	11,087,303,007.28
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,374,348.40	68,670,156.98
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	5,968,500.00	24,428,626.49
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	45,405,848.40	44,241,530.49
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	95,307,451,449.17	3,848,597,470.40
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	4,388,001,295.11	3,848,597,470.40
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	90,919,450,154.06	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-95,256,077,100.77	-3,779,927,313.42
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	90,919,450,154.06	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	90,919,450,154.06	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,140,586,696.31	7,011,143,777.19
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,299,301,150.68	7,011,143,777.19
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	109,414,366.39	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	731,871,179.24	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	81,778,863,457.75	(7,011,143,777.19)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	258,211,892.31	296,231,916.67
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	247,398,223.51	505,610,115.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	505,610,115.82	801,842,032.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	51,590,219,512.43	11,111,700,363.84	18,325,030,500.68	1,957,812,463.08	82,984,762,840.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-1,892,388,567.78	-1,892,388,567.78
5	Бусад дэлгэрэнгүй орлого			102,100,052.35		102,100,052.35
7	Зарласан ногдол ашиг				-731,871,179.24	-731,871,179.24
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-4,826,579.98		4,826,579.98	-
9	2024 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	51,590,219,512.43	11,106,873,783.86	18,427,130,553.03	-661,620,703.96	80,462,603,145.36
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-27,755,617,690.42	-27,755,617,690.42
13	Бусад дэлгэрэнгүй орлого			241,784,407.00		241,784,407.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	26,224,170,151.50	-		26,224,170,151.50
17	2025 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	51,590,219,512.43	37,331,043,935.36	18,668,914,960.03	-28,417,238,394.38	79,172,940,013.44

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024	2025		өсөлт/бууралт	
					төлөв	Гүйц	дүн	хувиар
1	ЦЭХ боловсруулалт		сая. кВтц	291.3	386.3	378.0	(8.3)	97.9%
2	ДХЦЭХ	хувиар	хувь	13.7%	14.0%	14.2%	0.0	98.9%
		биет	сая. кВтц	40.0	54.2	53.7	(0.5)	99.0%
3	Нийт түгээх ЦЭХ		сая. кВтц	320.3	373.6	372.9	(0.8)	99.8%
	Үүнээс:	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	251.3	332.0	324.3	(7.7)	97.7%
		ХАЦЭХ-ДҮТ	сая. кВтц	68.7	41.2	48.2	7.0	116.9%
		Импортын ЦЭХ	сая. кВтц	0.29	0.434	0.447	0.012	102.8%
4	Түгээх ДЭХ		мян.Гкал	343.5	352.3	366.8	14.4	104.1%
5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувиар	хувь	7.3%	4.5%	6.2%	1.7%	73.2%
		биет	сая. кВтц	23.4	17.0	23.1	6.2	136.3%
6	Борлуулах цахилгаан эрчим хүч		сая. кВтц	296.9	356.7	349.7	(6.9)	98.1%
7	Нийт орлого		сая.төг	85,955.4	111,070.0	109,463.8	(1,606.2)	98.6%
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	75,118.8	110,492.2	108,365.2	(2,127.0)	98.1%
		Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	10,836.6	577.8	1,098.6	520.8	190.1%
8	Нийт зардал		сая.төг	87,711.4	136,710.0	137,219.4	509.4	100.4%
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	70,228.0	107,671.7	107,552.2	(119.5)	99.9%
		Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	15,274.9	8,391.1	9,800.1	1,409.0	116.8%
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	1,501.3	17,871.9	17,091.9	(780.1)	95.6%
		50 мВт зардал	сая.төг	707.2	2,775.3	2,775.3	-	100.0%
9	Татвар төлөхийн өмнөх ашиг, / алдагдал/		сая.төг	(1,756.0)	(25,640.0)	(27,755.6)	(2,115.6)	108.3%
10	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал /		сая.төг	(1,892.4)	(25,640.0)	(27,755.6)	(2,115.6)	108.3%
11	БО-ын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.102	1.231	1.254	0.023	101.8%
12	Нийт авлага		сая.төг	3,005.6	4,154.5	3,916.700	(237.8)	94.3%
13	Нийт өр төлбөр		сая.төг	227,581.9	240,173.8	243,407.3	3,233.5	101.3%
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	202,050.0	205,739.8	209,457.0	3,717.2	101.8%
		БХӨТ	сая.төг	25,531.9	34,434.0	33,950.3	(483.7)	98.6%
14	Нийт ажилтан		сая.төг	695.0	740.0	720.0	(20.0)	97.3%
15	Нийт цалингийн сан		сая.төг	26,667.1	33,807.8	33,582.6	(225.2)	100.7%
17	Жишмэл түлшний хувийн зарцуулал	ЦЭХ	гр/кВтц	595.4	543.6	538.5	(5.1)	100.9%
		ДЭХ	кг/Г кал	191.8	191.0	190.1	(0.9)	100.5%
18	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	3,043.6	4,107.9	3,888.2	(219.8)	94.7%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах, цахилгаан импортлох, эрчим хүчний тоноглолд засвар туршилт хийх, цахилгаан, дулааны эрчим хүчний тоолуур гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах зэрэг 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Улс орны эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжил эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, хувийн хэвшил, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлд суурилсан үр ашигтай, хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи бүхий цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах чиглэлд бусад компаниудтай өрсөлдөхүйц компани болохыг тэргүүлэх чиглэлээ болгон ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон эдгээрийг дагалдаж гарсан журмуудыг мөрдөн ажиллаж байна.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын нэгж хэрэгжүүлж байна. Дотоод аудитын нэгжийн ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн тогтоох тухай” шийдвэр гарч, 21 нэгжид 740 албан хаагчийн орон тоотой байхаар баталсан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ий гүйцэтгэх захирлын 2016 оны А/322 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Эрчим хүч, дулаан үйлдвэрлэсэн үйлдвэрлэлийн зардлыг хамсарсан зардлыг хуваарилах аргаар тооцож бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэнэ гэж заасан байгаа ч борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээг “Грант торнтон аудит” ХХК-тай байгуулж, гэрээг дүгнэн, НБББББ-ийг гардан авсан боловч мөрдөж эхлээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,374.8 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	505,610.12	801,842.03	296,231.92
Авлага	3,005,579.24	3,916,683.58	911,104.34
Бараа материал	5,544,933.93	3,741,537.12	(1,803,396.80)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	22,289.50	28,341.15	6,051.64
Бусад эргэлтийн хөрөнгө	126,867.50	57,299.50	(69,568.00)
Үндсэн хөрөнгө	367,537,984.06	384,572,361.91	17,034,377.86
Нийт хөрөнгийн дүн	376,743,264.35	393,118,065.30	16,374,800.95
Богино хугацаат өр төлбөр	28,164,037.62	35,966,779.50	7,802,741.88
Урт хугацаат зээл	199,417,924.30	209,457,050.09	10,039,125.79
Хойшлогдсон орлого	68,698,699.28	68,521,295.70	(177,403.58)
Эздийн өмч	80,462,603.15	79,172,940.01	(1,289,663.13)
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	376,743,264.35	393,118,065.30	16,374,800.95

Нөлөө бүхий өөрчлөлт орсон данс нь өр төлбөр болон үндсэн хөрөнгийн данс байна. Бараа материалын дансны үлдэгдэл 3,741.5 сая төгрөг болж 1,803.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн саналын дагуу Захирлын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/71 дүгээр “Бараа материал акталж, данс бүртгэлээс хасах тухай” тушаалаар 142 нэр төрлийн 470 ширхэг 31.7 сая төгрөгийн бараа материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 384,572.4 сая төгрөг болж 17,034.4 сая төгрөгөөр өссөн байна. Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 1,771.2 сая төгрөгийн худалдан авалт хийж, 1,856.0 сая төгрөгийн капиталжуулалт хийгдсэн байна. ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн 26,224.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бүртгэсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 775 дугаар тогтоолоор 83 нэр төрлийн 99 ширхэг 430.7 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг акталж данснаас хассан, 791 дүгээр тогтоолоор 241.8 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг шилжүүлэн хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн 77 хувь буюу 282,163.9 сая төгрөг нь дуусаагүй барилга данс байна. “Чойбалсангийн ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-ын шинэ станцаар өргөтгөх” төсөл хэрэгжиж 2024 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан ч гүйцэтгэгч компанид дутуу ажлыг дуусгах үүрэг даалгавар өгсөн байна. Өгсөн үүрэг даалгаврын биелэлт бүрэн хэрэгжээгүй шалтгаанаар төслийн ажлыг одоо хүртэл хүлээн аваагүй, дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 35,966.8 сая төгрөг болж, 7,802.7 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн 66.7 хувь буюу 24,006.4 сая төгрөг нь төвийн эрчим хүчний системээс худалдаж авсан цахилгаан эрчим хүчний өглөг байна. Бэлтгэн нийлүүлэгч компаниудаас худалдан авсан нүүрс болон нүүрс тээврийн хөлсний өглөг 2,955.9 сая төгрөг байна.

Татварын өглөгийн үлдэгдэл өмнөх оноос 2,586.3 сая төгрөгөөр буурч 1,780.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 99.7 хувь нь нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг байна.

Урт хугацаат зээл дансны үлдэгдэл 209,457.0 сая төгрөг болж 10,039.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжсэн “Чойбалсангийн ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-ын шинэ станцаар өргөтгөх” төслийн Монгол Улсын хөгжлийн банканд төлөх зээлийн үлдэгдэл байна. Тайлант онд 7,087.7 сая төгрөгийн зээлийг төлсөн ч 17,448.5 сая төгрөгийн ханшийн зөрүү бодогдсоноос үүдэн зээлийн үлдэгдэл өссөн үзүүлэлттэй байна.

Хойшлогдсон орлого данс 68,521.3 сая төгрөг болж 177.4 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын элэгдлийн зардал болох 177.4 сая төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Эрчим хүчний сайдаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/16 дугаар тушаалаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт орлогыг 117,056.7 сая, нийт зардлыг 116,556.5 сая төгрөгөөр баталсан байна. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг 4,921.0 сая төгрөгөөр баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/238 дугаар тушаалаар нийт орлогыг 5,986.7 сая төгрөгөөр бууруулж, 111,070.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 20,153.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 136,710.0 сая төгрөг тус тус баталсан байна.

Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг 813.2 сая төгрөгөөр бууруулж 4,107.8 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 109,463.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 137,219.4 сая төгрөгийн зардал гарган, 27,755.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд цахилгаан, дулааны эрчим хүч болон импортын цахилгааны борлуулалтын орлого 108,365.2 сая төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 2,431.7 сая төгрөгөөр буурсан бол дулааны борлуулалтын орлого 304.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Цахилгаан эрчим хүчний түгээлтийн хүчин чадлын хязгаарлалт, оргил ачааллын горимын нөлөөгөөр уул, уурхай, газрын тос, ашигт малтмалын томоохон хэрэглэгчид болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан эрчим хүчний хэрэглээ 2,431.7 сая төгрөгөөр буурсан бөгөөд үүнээс үүдэн цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөгөөтэй харьцуулахад буурсан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого 577.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс 520.8 сая төгрөгөөр давж, 1,098.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Зардлын төлөвлөгөө 509.4 сая төгрөгөөр давсан бөгөөд нийт зардлын 12.8 хувь буюу 17,598.8 сая төгрөг нь валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/03 дугаар тушаалаар 2025 онд худалдан авах бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 12,030.4 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант онд батлагдсан төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн бөгөөд хамгийн сүүлд 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр А/879 дүгээр тушаалаар 9,379.2 сая төгрөгийн 98 бараа, ажил үйлчилгээ батлагдсан байна.

Батлагдсан төлөвлөгөөний 6,873.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 нэр төрлийн бараа, ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 35 нэр төрлийн 1,921.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 5 нэр төрлийн 179.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар, 34 нэр төрлийн

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

404.8 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар гүйцэтгэсэн байна. Батлагдсан төлөвлөгөөнөөс 39.6 сая төгрөгийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийх 1 үйлчилгээний гэрээ хийгдээгүй, он дамжсан байна. Бусад худалдан авалтууд бүрэн хийгдсэн байна.

Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүйд зөвлөмж өгсөн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компани/ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Оюунхэрлэн, Б.Одхүү, С.Энхбаатар нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Нармандах, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар хэрэгжүүлсэн.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК 2025 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/122 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Материаллаг байдлыг 2024 оны нийт орлогын 75,118.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 751.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд тус байгууллага нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулсан байна. Албан хаагчидтай холбоотой тушаал шийдвэрийг оруулахдаа нэрийг дарахгүй шууд байршуулж хувь хүний мэдээллийг ил болгосон байна.

4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорил, судалгааны үр дүн

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас дараах 5 нь хамааралтай байна. Үүнд:

1. *Хоол унааны хөнгөлөлт.* Компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 5.1 заалтыг үндэслэн 8.0 мянган төгрөгөөр олгож байна. Тайлант онд нийт 1,290.8 сая төгрөгийн хөнгөлөлт олгосон байна.

2. *Программ хангамж.* Санхүүгийн тайланд 1,130.8 сая төгрөгийн 20 нэр төрлийн программ хангамж бүртгэлтэйгээс 2 нэр төрлийн 19.4 сая төгрөгийн программ хангамж нь ашиглахгүй байна.

3. *Орон тооны цомхотгол* Тайлант онд бүтэц орон тоонд өөрчлөлт ороогүй байна.

4. *Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал.* Эрчим хүчний сайдын 2025 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн А/233 тоот тушаалаар баталсан 2025 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг шинэчлэн батлах тухай тушаалд сургалтын зардалд 137.6 сая төгрөг батлагдаж 102.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

5. *Төрийн өмчит үйлдвэрийн газрын судалгаа.* Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа, дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Эрчист Монгол ХХК эзэмшиж байна.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 26.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 226.1 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 351.2 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн шийдвэрийн биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	26.0	2	26.0	100
Албан шаардлага	3	226.1	3	226.1	100
Зөвлөмж	4	351.2	4	351.2	100
Нийт дүн	9	603.3	9	603.3	100

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь “банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна”, 4.1.5 дахь “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг” гэж заасны дагуу эдгээр хуулиудын үйлчлэх хүрээ, заалтуудад хамаарч байгаа тул Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 659.1 сая төгрөгийн 8 зөрчил¹ илэрснээс, 2.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 648.6 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 8.0 сая төгрөгийн 5 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн 659.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 92.1 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Эрчим хүчний сайдын 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/238 дугаар зорилтот түвшнийг шинэчлэн батлах тухай тушаалаар Биеийн тамир уралдаан тэмцээний зардлыг 8.9 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 11.4 сая төгрөгийн нийт зардал гаргаж, 2.5 сая төгрөгийн илүү зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим 4.1.Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.6.сахилга баттай байх; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 639.7 сая төгрөгийн 10 бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Биеийн тамир уралдаан тэмцээний зардалд нийт 8.9 сая төгрөгийн зардал зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3.1.3-д "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 3.2-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт: Эрчим хүчний сайдын А/16, А238 дугаар тушаалаар 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, 740 орон тоотой ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 720 хүний орон тоотой ажилласан ч орон тоог бууруулж, чиг үүргийн давхардлыг арилгах ажлыг зохион байгуулаагүй байна. Энэ нь УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу "бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх" арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллах

2. Илрүүлэлт: Компанийн нийт авлага 3,916.7 сая төгрөг болж өмнөх оноос 911.1 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд дансны авлага буюу борлуулалтын авлага 674.5 сая төгрөгөөр, НӨАТ-ын авлага 216.2 сая төгрөгөөр бусад авлага 20.4 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд компанийн нийт өр төлбөр 313,945.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд 35,966.6 сая төгрөг буюу 11.5 хувь нь богино хугацаат, 277,978.3 сая төгрөг буюу 88.5 хувь нь урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Богино хугацаат өр төлбөр нь 2025 онд Төвийн эрчим хүчний системээс эрчим хүч худалдан авч үүссэн 24,006.4 сая төгрөгийн өр төлбөр, 1,780.9 сая төгрөгийн татварын өглөг 4,939.3 сая төгрөгийн хүүгийн өглөг, 2,016.6 сая төгрөгийн урьдчилж орсон орлого зэрэг байгаа бол урт хугацаат өр төлбөрт Германы сэргээн босголтын банк болон дэлхийн банкны зээлийн үлдэгдэл 4,667.6 сая төгрөг, МУ-ын хөгжлийн банкнаас авсан зээлийн үлдэгдэл 209,022.5 сая төгрөг, хойшлогдсон орлогын үлдэгдэл 68,521.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оноос өр төлбөрийн үлдэгдэл 17,664.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төвийн эрчим хүчинд төлөх 24,006.4 сая төгрөгийн өр төлбөр үүссэн, хөгжлийн банкнаас авсан зээлийн валютын ханшны зөрүүнд 17,598.9 сая төгрөгийн алдагдал хүлээсэн зэрэг нь нөлөөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д "төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах зөвлөмж өгөх

3. Илрүүлэлт: Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.5-д "тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, журмын дагуу цахим системд худалдан авах ажиллагааны үр дүнг мэдээлж байх

4. Илрүүлэлт: Монгол Улсын Эрчим хүчний яам нь БНХАУ-ын "ТБЕА" компанитай 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр "Түлхүүр гардуулах нөхцөлтэй Чойбалсангийн дулааны

цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төслийн ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажлыг гүйцэтгэн, төслийн ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 30-нд хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан байна.

Төслийн ажлыг хүлээн авах нээлтийн ажиллагааг 2024 оны 06 дугаар сард зохион байгуулж, ажлыг хүлээн авах улсын комисс тайлант оны 10 дугаар сард ажиллаж гүйцэтгэгч компанид дутуу ажлыг дуусгах үүрэг даалгавар өгсөн байна. Өгсөн үүрэг даалгаврын биелэлт бүрэн хэрэгжээгүй тул төслийн ажлыг одоо хүртэл хүлээн аваагүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн ажлыг бүрэн хүлээн авах ажлыг зохион байгуулах

5. Илрүүлэлт: 2019 онд үүссэн урьдчилж төлсөн тооцооны 8.0 сая төгрөгийн авлага нь Шүүх, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлсэн ч одоо хүртэл барагдаагүй байна. Энэ нь Шүүхийн захирамжийг сайн дураар биелүүлээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь "Энэхүү захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. гэж заасны дагуу ирүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2019 онд үүссэн урьдчилж төлсөн тооцооны 8.0 сая төгрөгийн авлага нь Шүүх, хяналтын байгууллагаар шийдвэрүүлсэн ч одоо хүртэл барагдаагүй	1	8,000.00					1	8,000.00
Тайлант хугацаанд 639.7 сая төгрөгийн 10 бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.	1	639,704.08			1	639,704.08		
Худалдан авах ажиллагааны <i>tender.gov.mn</i> цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүй	1	-					1	-
Эрчим хүчний сайдын А/16, А238 дугаар тушаалаар 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, 740 орон тоотой ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 720 хүний орон тоотой ажилласан ч орон тоог бууруулж, чиг үүргийн давхардлыг арилгах ажлыг зохион байгуулаагүй байна.	1	-					1	-
Биеийн тамир уралдаан тэмцээний зардалд 8.9 сая төгрөгийн зардал зарцуулсан байна.	1	8,915.00			1	8,915.00		
Компаний нийт авлага 3,916.7 сая төгрөг болж өмнөх оноос 911.1 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд дансны авлага буюу борлуулалтын авлага 674.5 сая төгрөгөөр, НӨАТ-ын авлага 216.2 сая төгрөгөөр бусад авлага 20.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд компаний нийт өр төлбөр 313,945.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	-					1	-
Монгол Улсын Эрчим хүчний яам нь БНХАУ-ын ТБЕА компанитай 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр “Түлхүүр гардуулах нөхцөлтэй Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төслийн ажлыг бүрэн хүлээлгэн өгөөгүй	1	-					1	-
Биеийн тамир уралдаан тэмцээний зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлж зарцуулсан	1	2,504.31	1	2,504.31				
	8	659,123.39	1	2,504.31	2	648,619.08	5	8,000.00